



МОНГОЛ УЛС
ТӨВ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 01 сарын 08 өдөр

Дугаар А/12

Зуунмод

Газар эзэмших эрх шилжүүлэх
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3, 29.1.6, 29.2 дахь хэсэг, Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1, 38.4, Засгийн газрын 2016 оны 193 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Зуунмод сумын 6-р багийн нутаг дэвсгэрт байрлах газар эзэмших эрхийн 0235052 дугаар бүхий гэрчилгээтэй 18646288708202 нэгж талбарын дугаартай складын зориулалттай 240 м² газрыг Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв /9061185/-аас Зуунмод сумын Засаг даргын Тамгын газар /9058923/-т төрийн байгууллагын албан конторын зориулалтаар Баруун зуунмод 6-р баг, Энхтайваны 106 тоот хаягт 15 жилийн хугацаатайгаар эрх шилжүүлэн эзэмшүүлсүгэй.

2. Газар эзэмшигч Зуунмод сумын Засаг даргын Тамгын газар /П.Цэлмэг/-т дараах үүргийг хариуцуулсугай.

2.1. Газрыг зориулалтын дагуу ашиглах.

2.2. Газрын кадастрын зураглалыг мэдээллийн санд бүртгүүлж баталгаажуулан газар эзэмших эрхийн гэрчилгээг авах.

2.3. Газар эзэмших гэрээ байгуулж, гэрээг жил бүр дүгнүүлэн газрын төлбөрийг хугацаанд нь бүрэн төлж байх.

3. Аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар /М.Отгонбат/, Зуунмод сумын Засаг дарга/Г.Мөнхбадрал/ нарт дараах ажлыг үүрэг болгосугай.


3.1. Газар эзэмшигчтэй гэрээ байгуулж дүгнэж ажиллах.

3.2. Газрын мэдээллийн санд бүртгэж, гэрчилгээг олгох.

3.3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавих.

4. Энэ захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2009 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 572 дугаар захирамж болон газар эзэмших эрхийн 0235052 дугаартай гэрчилгээг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Ж.БАТЖАРГАЛ